



128

**БНМАУ**  
**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 09 сарын 28

№ 62

Улаанбаатар хот

**Хүүхдийн "Итгэл" төв байгуулах тухай**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 44 дүгээр чуулганаас баталсан "Хүүхдийн эрхийн тухай" конвенцийн 20 дугаар зүйл, Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүлэгчдийн 1991 оны 10 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас **ТОГТООХ нь:**

1. Хүүхдийн "Итгэл" төвийг 72 ортойгоор байгуулан ажиллуулахыг хотын Боловсролын газар /н.Чимэддорж/-т цаалгасугай.

2. Зөвлөлтийн барилгын III трестээс хүлээж авсан "Төмөр зам" хороолол цахь цотуур байрн зориулалттай байрыг "Итгэл" төвийн мэдэлд олгосугай.

3. Хүүхдийн "Итгэл" төвийн зардлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган санхүүжүүлэхийг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тэргүүн цэд дарга н.Ганхуяг, хотын Санхүүгийн газар /н.Гонгор/, хотын Боловсролын газар /н.Чимэддорж/-т тус тус цаалгасугай.

4. "Итгэл" төвийн байранд оруулах хүүхдүүцийн асууцлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, асрагч хүмүүжүүлэгч, эцэг эх, сургууль, багш нартай нь байнгын холбоотой ажиллан, тэдгээр хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, амьдралын зөв байр суурь төлөвшүүлэхэд чиглэсэн өдөр тутмын удирдлага, тусалцаагаар ханган ажиллаж, энэ төвийн үйл ажиллагааны талаар 1993 оны I улиралд Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргааны хуралдаанд танилцуулахыг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисс /н.Сарантуяа/, хотын Хүүхдийн байгууллагын зөвлөлд тус тус цаалгасугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Орон сууц хуваарилах тухай" Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны I дүгээр сарын 24-ний өдрийн 46 дугаар тогтоолын I дүгээр хавсралтын" 23, Өнчин, тэнүүлчин хүүхдүүдэд 32 айл" гэснийг хүчингүй болсонд тооцож, уг сууцыг орон сууц хуваарилах журмын дагуу дахин хуваарилаж олгохыг Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ хариуцсан дэд дарга н.Баасанжавт зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА - 2

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА

*JSE*

Л.ЭНЭБИШ

*Ч.Сумаахүү*

Ч.СУМААХҮҮ